“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын насан туршийн боловсролын төв 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 99389927 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/249
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ Б.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Насан туршийн боловсролын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Мөрөн сумын Насан туршийн боловсролын төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний дараах зөрчлүүд илэрсэн болно. Үүнд:

1. Байгууллагын гэрээт нягтлан бодогч нь тушаал шийдвэрт зааснаас 2,537.8 мянган төгрөгөөр илүү цалин тооцож авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
2. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1,353.0 мянган төгрөгийн сейф биетээр байхгүй, дутагдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг

болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ" заасныг тус тус зөрчсөн, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Мөрөн сумын Насан туршийн боловсролын төв нь 7 орон тоотойгоор байгуулагдаж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагагаа явуулж эхэлсэн байна. Тайлант онд орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 4,503.8 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 583.0 мянган төгрөгийн, төсвийн зарцуулалттай холбоотой 2,093.8 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэрийг гаргасан болно

Бусад асуудлын хэсэг

Мөрөн сумын Насан туршийн боловсролын төв нь 2025 оны сүүлийн хагас жилд гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд 3 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 76.5 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан */төгрөгөөр/*

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**56,026,095.04**	**78,118,407.52**
31	**МӨНГӨН ХӨРӨНГӨ**	49,503,095.04	73,406,907.52
312	**Банкинд байгаа бэлэн мөнгө**	49,503,095.04	73,406,907.52
3121	**Төгрөг**	49,503,095.04	73,406,907.52
31211	Төрийн сангийн харилцах	49,503,095.04	73,406,907.52
35	**БАРАА МАТЕРИАЛ**	6,523,000.00	4,711,500.00
354	**Хангамжийн материал**	6,523,000.00	4,711,500.00
35410	Бичиг хэргийн материал	82,000.00	82,000.00
35420	Аж ахуйн материал	3,590,000.00	3,372,700.00
35470	Бусад хангамжийн материал	1,256,800.00	1,256,800.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**27,149,277.70**	**23,607,027.90**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	27,149,277.70	23,607,027.90
392	**Биет хөрөнгө**	27,149,277.70	23,607,027.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,246,903.08	35,160,803.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,271,253.50	-20,754,746.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,094,700.00	19,094,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,001,071.88	-9,973,728.74
39217	Ном	80,000.00	80,000.00
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**83,175,372.74**	**101,725,435.42**
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**83,175,372.74**	**101,725,435.42**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	83,175,372.74	101,725,435.42
512	**Хуримтлагдсан үр дүн**	83,175,372.74	101,725,435.42
51210	Өмнөх үеийн үр дүн	83,175,372.74	83,175,372.74
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	18,550,062.68
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**83,175,372.74**	**101,725,435.42**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. *Санхүүгийн үр дүнгийн тайлан* */төгрөгөөр/*

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**216,428,100.00**	**256,892,506.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**6,253,900.00**	**14,683,506.00**
120	**Нийтлэг татварын бус орлого**	6,253,900.00	14,683,506.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,253,900.00	10,649,606.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,649,606.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,000,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		4,033,900

13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**210,174,200.00**	**242,209,000.00**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	199,974,200.00	232,435,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	199,974,200.00	232,435,000.00
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	10,200,000.00	9,774,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,200,000.00	9,774,000.00
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**214,567,561.97**	**238,342,443.32**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**214,567,561.97**	**238,342,443.32**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	213,373,938.77	232,628,314.92
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	170,242,093.00	183,437,182.47
210101	Үндсэн цалин	109,226,166.00	111,024,635.24
210102	Нэмэгдэл	50,643,175.00	53,331,046.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	11,347,321.65
210104	Урамшуулал	10,372,752.00	7,734,179.34
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	21,247,941.49	23,213,911.05
210201	Тэтгэврийн даатгал	15,526,516.30	15,871,496.73
210202	Тэтгэмжийн даатгал	1,228,744.30	1,806,258.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	729,201.31	1,035,514.28
210204	Ажилгүйдлийн даатгал	710,420.83	893,505.59
210205	Эрүүл мэндийн даатгал	3,053,058.75	3,607,135.96
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	5,006,376.80	3,059,871.60
210302	Түлш, халаалт	5,006,376.80	2,286,871.60
210303	Цэвэр, бохир ус	00.00	773,000.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	00.00	3,807,100.00
210401	Бичиг хэрэг	00.00	3,807,100.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	1,998,300.00	1,594,200.00
210604	Урсгал засвар	1,998,300.00	1,594,200.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	14,879,227.48	17,516,049.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,397,530.00	8,426,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,200,700.00	633,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,280,997.48	8,456,149.80
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	1,193,623.20	5,714,128.40
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2134	**Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт**	1,193,623.20	5,714,128.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,193,623.20	5,714,128.40
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)**	**1,860,538.03**	**18,550,062.68**

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

***Хүснэгт 3**. Өмч өөрчлөлтийн тайлан* */төгрөгөөр/*

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	**2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	00.00	00.00	39,894,099.10	00.00	39,894,099.10
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,180,753.60	00.00	3,180,753.60
C08	**2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**00.00**	**00.00**	**83,175,372.74**	**00.00**	83,175,372.74
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	18,550,062.68	00.00	18,550,062.68
D09	**2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**00.00**	**00.00**	**101,725,435.42**	**00.00**	101,725,435.42

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. *Мөнгөн гүйлгээний тайлан* */төгрөгөөр/*

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)**	**210,174,200.00**	**252,858,606.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**00.00**	**10,649,606.00**
120	**Нийтлэг татварын бус орлого**	00.00	10,649,606.00
120004	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	00.00	10,649,606.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,649,606.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,000,000.00
122002	Хандив тусламж /гадаад/		
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**210,174,200.00**	**242,209,000.00**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	199,974,200.00	232,435,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	199,974,200.00	232,435,000.00
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	10,200,000.00	9,774,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,200,000.00	9,774,000.00
2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)**	**210,302,064.49**	**228,074,793.52**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**210,302,064.49**	**228,074,793.52**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**209,108,441.29**	**222,360,665.12**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	171,203,062.85	183,437,182.47
210101	Үндсэн цалин	108,819,184.85	111,024,635.24
210102	Нэмэгдэл	51,136,276.00	53,331,046.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	11,347,321.65
210104	Урамшуулал	11,247,602.00	7,734,179.34
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	20,286,971.64	23,213,911.05

210201	Тэтгэврийн даатгал	12,539,355.83	15,871,496.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,147,376.86	1,894,515.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	958,859.31	947,257.62
210204	Ажилгүйдлийн даатгал	942,629.99	893,505.59
210205	Эрүүл мэндийн даатгал	3,698,749.65	3,607,135.96
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	5,006,376.80	3,059,871.60
210302	Түлш, халаалт	5,006,376.80	2,286,871.60
210303	Цэвэр, бохир ус	00.00	773,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	4,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	1,000,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	8,612,030.00	11,649,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,312,800.00	7,349,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,299,230.00	4,299,900.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**1,193,623.20**	**5,714,128.40**
2134	**Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт**	1,193,623.20	5,714,128.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,193,623.20	5,714,128.40
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)**	**-127,864.49**	**24,783,812.48**
5	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)**	**80,000.00**	**880,000.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**80,000.00**	**880,000.00**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	80,000.00	880,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	80,000.00	880,000.00
6	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)**	**-80,000.00**	**-880,000.00**
8	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)**	-207,864.49	23,903,812.48
9	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	49,710,959.53	49,503,095.04
10	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	49,503,095.04	73,406,907.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

***Хүснэгт 5**. төсвийн гүйцэтгэлийн тайлан* */Төгрөгөөр/*

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	**288,040,000.00**	**252,858,606.00**	**35,181,394.00**	100.00%
Улсын төсвөөс	232,435,000.00	232,435,000.00	0.00	100.00%
Орон нутгийн төсвөөс	9,774,000.00	9,774,000.00	0.00	100.00%

Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		8,649,606.00	-8,649,606.00	100.00%
Туслах үйл ажиллагааны орлого	2,000,000.00	2,000,000.00	0.00	
Урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх	45,831,000.00			
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	**288,040,000.00**	**252,858,606.00**	**35,181,394.00**	100.00%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	**288,040,000.00**	**228,954,793.65**	**59,085,206.35**	
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	**237,036,400.00**	**183,437,182.50**	**53,599,217.50**	99.40%
Цалин	165,748,900.00	111,024,635.00	54,724,265.00	95.97%
Цалингийн тусгай нэмэгдлүүд	71,287,500.00	61,065,225.85	10,222,274.15	106.10%
Унаа хоолны хөнгөлөлт		11,347,321.65		
Нийгмийн хамгааллын шимтгэл	**29,629,600.00**	**23,213,911.05**	**6,415,688.95**	98.45%
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	24,888,900.00	19,606,775.09	5,282,124.91	98.72%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,740,700.00	3,607,135.96	1,133,564.04	97.06%
Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	**8,774,000.00**	**3,059,871.70**	**5,714,128.30**	100.00%
Гэрэл цахилгааны зардал	3,000,000.00		3,000,000.00	100.00%
Түлш, халаалтын зардал	5,000,000.00	2,286,871.70	2,713,128.30	100.00%
Цэвэр, бохир усны зардал	774,000.00	773,000.00	1,000.00	100.00%
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	**12,600,000.00**	**13,529,700.00**	**-929,700.00**	97.20%
Бусад бараа үйлчилгээний зардал	6,300,000.00	8,229,800.00	-1,929,800.00	99.60%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	4,300,000.00	4,299,900.00	100.00	100.00%
Урсгал засварын зардал	2,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	100.00%
Урсгал шилжүүлэг	**0.00**	**5,714,128.40**	**-5,714,128.40**	97.39%
Төвлөрүүлэх шилжүүлэг		5,714,128.40	-5,714,128.40	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		49,503,095.04	-49,503,095.04	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		73,406,907.52	-73,406,907.52	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43,089.9 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 43,089.9 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд тоног, төхөөрөмжийн дүнг 1,659.3 мянган төгрөгөөр,авлагын дүнг 112.5 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайланд орлогын дүнг 18,481.2 мянган төгрөгөөр алдаатай илэрсэн
2. Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийн орлогыг 6,220.0 мянган төгрөгөөр илүү, бусад орлогыг 2,429.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн
3. Нэр бүхий ажилтнуудад 14,187.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, цалин, ээлжийн амралтын олговор зэргийг илүү тооцож олгосныг аудитын хугацаанд орон нутгийн төсвийн дансанд төлж барагдуулсан .

Аудитаар нийт 112,907.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 3,890.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 109,017.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

1. Гэрээт нягтлан бодогчид 2,537.9 мянган төгрөгийн цалинг тушаал шийдвэргүйгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
2. Тайлант онд 1,353.0 мянган төгрөгөөр худалдан авсан сейфийг дутагдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, гэж заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

3.2 Албан шаардлага хүргүүлээгүй.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Тайлант оны 12 дугаар сард худалдаж авсан 583.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Өгсөн зөвлөмж:

1. Санхүүгийн программыг бүртгэлд тусгах;

2.Илрүүлэлт:

Тайлант онд ажилтнуудын ажлыг дүгнэлгүйгээр 2,093.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 1-т "Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор ур чадварын нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө", 3-т "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно", гэснийг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж:

Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг үндэслэлтэй боловсруулах, уг нэмэгдэлд хамрагдсан ажилтан нь бусдаас илүү чадварлаг, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй, байгууллагад үр ашигтай ажилласныг баримтжуулж хэвших;

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

3.Илрүүлэлт:

Дотоод хяналтын нэгж болон эд хариуцагчийг томилон ажиллуулаагүй нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.1-д " Энэхүү журмын 1.3-т заасан дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан гүйцэтгэнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-д "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна." гэж заасныг тус тус зөрчсөн, . нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын нэгж болон эд хариуцагчийг томилон ажиллуулах,

4.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг 106,340.2 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт 6. *Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*

/мянган төгрөгөөр/

Алдаа ны товч утга	Нийт алдаа		Мэдээлийг тусгахгүй орхиг дуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэр бүхий ажилт нуудад ур чадварын нэмэг дэл цалин, ээлжийн амралтын олговор илүү тооцож олгосон	1	14,187.2			1	14,187.2	1	14,187.2				
Санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайланд алдаа илэрсэн.	1	20,253.0			1	20,253.0	1	20,253.0				
Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжил тийн орлогыг илүү илэрхийлсэн	1	8,649.6			1	8,649.6	1	8,649.6				
Дүн	**3**	**43,089.9**			**3**	**43,089.9**	**3**	**43,089.9**				

Хүснэгт 7. *Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн программыг бүртгэлд тусгаагүй.	1	583.0					1	583.0

Ажилтанд тушаал шийдвэргүйгээр цалин тооцож олгосон.	1	2,537.9	1	2,537.9				
Тайлант онд худалдан авсан сейфийг дутагдуулсан	1	1,353.0	1	1,353.0				
Ажилтнуудын ажлыг дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон	1	2,093.8					1	2,093.8
Дүн	**5**	**6,567.7**	**2**	**3,890.9**			**2**	**2,676.8**

Хүснэгт 8. *Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал*

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илэрсэн.								
Дотоод хяналтын нэгж болон эд хариуцагчийг томилон ажиллуулаагүй.	1	0.0					1	0.0
Шилэн дансанд мэдээллийн мөнгөн дүнг үнэн зөв байршуулаагүй	1	106,340.2					1	106,340.2
Дүн	**2**	106,340.2					**2**	106,340.2